



ХЭРХЭН ХОГГҮЙ АЯЛАХ ВЭ?

**АЯЛАГЧДАД ЗОРИУЛСАН
ЗААВАРЧИЛГАА**

Улаанбаатар хот
2022 он

Энэхүү зааварчилгааг Европын Холбооны SWITCH Asia-II хөтөлбөрөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийн хүрээнд бэлтгэв. Зааварчилгаанд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

АГУУЛГА

- 01.** Хоггүй аялах 10 шалтгаан
- 02.** Хоггүй аяллыг төлөвлөх, бэлтгэх нь
- 03.** Гаргасан хог хаягдлаа (дахивар) ангилах алхмууд
- 04.** Байгальд ээлтэй аялах бусад арга замууд
- 05.** Байгальд ээлтэй бүтээгдэхүүн худалдаалдаг дэлгүүрүүд
- 06.** Орон нутгийн дахивар тушаах байршлууд болон холбоо барих мэдээлэл
- 07.** Хог хаягдалтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг ААН
- 08.** Төрийн бус байгууллагууд болон олон нийтийн бүлгүүд

01 ХОГГҮЙ АЯЛАХ 10 ШАЛТГААН



Байгальд санаатай болон санамсаргүй ил задгай хаягдсан хог хаягдлыг түүх, төвлөрүүлэх, тээвэрлэх нь өнөөдрийн хогны менежментэд тулгараад буй хамгийн бэрхшээлтэй асуудлуудын нэг болоод байна. Орон нутагт хаягдсан хог хаягдлын 1 хүрэхгүй хувь дахин боловсруулагдаж, 99% нь тухайн газрын хөрсөнд булдагд байна. Хээр хөдөө хаягдсан хогийг цуглуулах ачилт, тээвэр, хөдөлмөрийн хүч, ложистик шийдвэрлэх боломжгүй учраас хог хаягдлыг үүсгэхгүй байхаас эхлэн, бууруулах, нэгэнт гаргасан бол ангилж ялган эцсийн хаягдлыг хамгийн бага байлгах нь аялагч бүрийн эрхэм үүрэг хариуцлага мөн болно.

1 ОРОН НУТАГТ ИХ ХЭМЖЭЭНИЙ ХОГ ҮҮСЭХЭЭС СЭРГИЙЛНЭ

Аялагчид орон нутгийн иргэдээс 2 дахин их хог хаягдал гаргадаг гэх судалгаа байдаг[1]. Тиймээс хоггүй аялах эсвэл маш бага үүсгэх нь орон нутгийн хогийн цэгийн зай талбайг хэмнэнэ.



2 АГААР, ХӨРС, УСНЫ БОХИРДЛООС СЭРГИЙЛНЭ

Зарим хог байгальд задарч шимэгдэж дуустал хөрс, ус, агаарт сөрөг нөлөөллийг байнга үзүүлдэг бөгөөд хуванцар сав баглаа боодол байгальд хэзээ ч бүр мөсөн задардаггүй. Хуванцар нь цаг хугацаа өнгөрөх тусам бичил, nano хэсгүүд болон задрах боловч байгальд огт шингэдэггүй. 20-хон минут хэрэглээд хаях хэрэггүй болсон зүйлс 200 жил ч оршин байна гэсэн үг. Та байгалийн сайханд тав тухтай аялсан бол хог үүсгэхээс татгалзаж талархсанаа илэрхийлээрэй.

3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛНА

Аялагчдын орхиж үлдээсэн хог хаягдал байгалийн олон янз байдалд маш сөрөг нөлөөтэй бөгөөд зарим тохиолдолд үхлийн аюул ч дагуулдаг. Шувуудын гэдсэнд орсон метал, хуванцар бөглөөнүүд эсвэл савлагаанд гацаж биеийн гаж хөгжилтэй болсон амьтдын зурагнуудыг та харсан байх. Хэн нэгэнд гэмтэл хохирол учруулахгүйн тулд хариуцлагатай байж ил задгай хог үлдээхгүй аялаарай.



4 БАЙГАЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦИЙГ ХЭМНЭНЭ

Байгалиас олборлож буй бүх төрлийн ашигт малтмал, газрын ба ойн баялаг, түүхий эдийг хэмнэхээс гадна ус, ургамал, амьтад, хуурай газрын ашиглалтыг бууруулдаг. Хог болох зүйлээс татгалзвал байгалийн хязгаарлагдмал нөөцийг хэмнэж биологийн олон янз байдлыг хамгаалж, ирээдүй хойчдоо хэрэглэх нөөцийг нь үлдээх хариуцлагатай үйлдэл юм.



[1] Sustainable Travel International. "Tackle waste & pollution" Sustainabletravel.org, 2020.
URL: www.sustainabletravel.org



5

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛНА

Хог хаягдлын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг савлагаанаас татгалзах, эсвэл ангилан тушаах нь түүхий эд материалын олборлолт ба үүнээс үүдэх хүлэмжийн хийн ялгаруулалтыг 37%-100% багасна[2].

6

ГҮНИЙ УСЫГ ХАМГААЛДАГ

Үүсэх эцсийн хог хаягдлын хэмжээ буурсанаар хөрс цаашлаад гүний усанд нэвчиж болзошгүй бохирдлоос сэргийлж чадна. Хог хаягдал устай нэгдэн задарснаар органик болон органик бус уусамтгай хорт нэгдлүүдийг үүсгэн бидний амьдралын зайлшгүй хэрэгцээт гүний усыг бохирдуулж байдаг байна. Мөн хогийн цэгээс ялгарч буй энэхүү хортой шингэн нь усны амьд организм, гол горхид нэвчвэл хүний эрүүл мэндэд шууд болон суурь өвчин үүсгэх шалтгаан болдог. Жишээ нь хэрэв тухайн ялгарсан шингэн хортой метал агуулсан бол хүний эрүүл мэндэд шууд сөргөөр нөлөөлнө.



7

ОЛОН ТӨРЛИЙН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛНЭ

Хог хаягдлаас ялгарах хортой бодисууд амьсгалын зам, зүрх судас, хоол боловсруулах эрхтэн, харшил болон архаг хууч өвчлөлүүдийг үүсгэх эрсдэлтэй байдаг. Хог хаягдал нийгмийн сэтгэл зүйд ч сөргөөр нөлөөлдөг. Аялагчдын сэтгэл зүйд хогны асуудал хамгийн хүчтэй сөрөг нөлөөг бий болгодог.

8

НҮҮДЭЛЧДИЙН УЛАМЖЛАЛТ СОЁЛОО ХАДГАЛНА

Монголын нүүдэлчин соёлд байгальдаа хог хаягдалгүй, ул мөр багатай амьдарч ирсэн уламжлалтай. Энэ ёс заншил, ухааныг сэргээж үр хойчдоо өвлүүлэн уламжилна.



9

ӨӨРИЙН ЭКОЛОГИЙН УЛ МӨРИЙГ БУУРУУЛНА

Монгол хүний экологийн ул мөр дэлхийн дунджаас даруй 2.8 дахин их хэмжээтэй байна гэсэн тооцоо гарчээ. Иймээс өөрөөс хамаарах экологийн ул мөрөө бууруулах нь маш чухал үр нөлөөтэй.

10

ИРЭЭДҮЙ ХОЙЧДОО БАЯЛАГ ӨВИЙГ ҮЛДЭЭНЭ

Хог үүсгэхгүй, ул мөргүй аялах нь ирээдүй хойчдоо үлдээх хамгийн том өв баялаг болно.



[2] Blue, Marie-Luise. "What is the carbon footprint of a plastic bottle?" Sciencing.com, June 11, 2018. URL: www.sciencing.com

02 ХОГГҮЙ АЯЛЛЫГ ТӨЛӨВЛӨХ, БЭЛТГЭХ НЬ



Доорх нэг удаагийн хэрэгслүүдийг хэрэглээд хаяхаас татгалзаж олон удаа хэрэглэх бүтээгдэхүүн, хэрэглэлүүдийг сонгон авч яваарай. Мөн худалдан авалтаа хийхдээ аль болох савлагааг салган дахиврын цэгүүдэд тушааж болохуйцаар зохицуулалт хийгээрэй. Жишээ нь будаа, ногоо гэх мэт кг-ийн бараа бүтээгдэхүүнийг байнга хэрэглэх жижиг даавуун уутнуудад юүлээд савлагааг нь дахиварт тушааж болно. Энэ нь мөн зай талбай хэмнэх давуу талтай.



ХАЛБАГА, СЭРЭЭ, ХУТГА, СОРУУЛ: Аялалд зайлшгүй авч явах хэрэгсэл бөгөөд нэг удаагийн халбага сэрээнээс татгалзаж орлуулахад их хэмжээний хог үүсэхээс сэргийлнэ. Нэг удаагийн соруулыг орлуулж болох төмөр, хулсан, силиконон гээд маш олон сонголт бий.



ХАЛУУНАА БАРЬДАГ АЯГА: Бидний өдөр тутмын эрч хүч энерги авдаг зүйл маань яах аргагүй халуун кофе байдаг ч үүнийгээ дагаад нэг удаагийн хэрэглээ өдөр өдрөөр ихсэж буй. Хэрэв бид өөрийн аягаа авч явж хэвшвэл жилд 500 ширхэг нэг удаагийн аяганаас татгалзах боломжтой.



УСНЫ САВ: Маш их хэмжээний хог хаягдал үүсэхээс сэргийлж болох хамгийн энгийн арга бол усны саваа өөртөө авч явах. Та усны савтай явсанаар дэлхий дээр өдөрт зарагддаг 1,5 тэрбум хуванцар савыг багасгахад хувь нэмрээ оруулж байна гэсэн үг юм. Нэг сав ус худалдан авахад та дан ганц хуванцарын хог үүсгэж байгаа биш түүнийг үйлдвэрлэхэд болон тээвэрлэхэд ашиглагдсан нүүрсхүчлийн хийг өөрийн экологийн ул мөр дээрээ нэмж байна гэсэн үг. Бид маш их хэмжээний нэг удаагийн хэрэгсэл ашигладаг боловч 10 хүрэхгүй хувь нь дахин боловсруулагддаг байна. Дахин боловсруулагдаагүй хуванцар нь хогийн цэг, хог шатаах зуух бүр цаашлаад далайд тэнгист хуримтлагддаг.



УС ЦЭВЭРШҮҮЛЭГЧ: Ус цэвэршүүлэгч авч явах нь савлагаатай уснаас татгалзах хамгийн сайн арга болдог.




ХУЛСАН ШҮДНИЙ СОЙЗ: Сойз нь олон төрлийн хуванцраас бүрдэг дахин боловсруулагдахад төвөгтэй бүтээгдэхүүн бөгөөд хуванцарыг орлох байгальд ээлтэй хулсан сойз элбэг болсон байна.



ҮСНИЙ ХАТУУ ШАМПУНЬ, АНГИЖРУУЛАГЧ: Хуванцар савтай шампуниас татгалзсанаар их хэмжээний хаягдал үүсэхээс сэргийлж чадна. Нэг хатуу шампунь нь 80 хүртэл угаалтад хүрэх буюу 2-3 сав шингэн шампуньтай тэнцэнэ.



ДААВУУН ТОР, УУТНУУД: Дахин ашиглагдах даавуун тор, уутнуудыг ашиглан гялгар уутнаас татгалзсанаар та эх дэлхийнхээ тогтвортой байдлыг хадгалахад маш том хувь нэмэр оруулж байгаа юм. Та хэд хэдэн даавуун торыг авч явбал олон зориулалтаар ашиглаж болно.



ДАХИН АШИГЛАДАГ ХООЛНЫ САВ: Хоолны сав авч явах нь зай эзэлсэн, овортой эсвэл шаардлагагүй санагдаж болох ч илүүдэл хоолны хаягдал мөн байгальд хамгийн их хаягддаг хуванцар хаягдлыг үүсэхээс сэргийлж, багасгаж чадна.



ХОГ ХАЯГДАЛГҮЙ АЯГА ТАВАГ УГААГЧ: Энэхүү аяга угаагч нь хуванцарын бохирдол үүсгэхгүйгээс гадна бусад энгийн угаагчид агуулагддаг хортой химийн бодисууд агуулдаггүйгээрээ онцлог.



ЭКО УГААЛГЫН НУНТАГ: Эдгээр нь байгаль орчин, эрүүл мэндийг хордуулах хүчтэй химийн бодисууд агуулдаггүйгээрээ онцлогтой.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АРИУН ЦЭВРИЙН ХЭРЭГСЭЛ: Нэг удаагийн ариун цэврийн хэрэгслийн оронд сарын тэмдгийн аяга, угаадаг даавуун хэрэгсэл хэрэглэх нь аялалын туршид үүсэх хогноос сэргийлэхээс гадна таныг тав тухтай байлгаж чадна. Мөн эдийн засагт ч хэмнэлттэй.



ЭКО ХҮҮХДИЙН ЖИВХ: Бага насны хүүхэдтэйгээ аялахад хамгийн ихээр үүсдэг хог хаягдлын нэг нь яах аргагүй хүүхдийн живх юм. Хуванцрын орцтой хүүхдийн живх хөрсөнд задрах хүртлээ аюултай бичил хуванцар болдог учир хэрхэвч хөдөө хээр хаяж болохгүй. Үүний оронд байгальд ээлтэй угаадаг даавуун живх, эсвэл 100% цэвэр хөвөн даавууны орцтой живх хэрэглэж хэвших, хэрэв нэг удаагийн живх хэрэглэсэн бол төвлөрсөн цэгт хаях шаардлагатай.



САЛФЕТКА, 00 ЦААС: Дийлэнх нойтон салфеткууд нь хуванцар бүтээгдэхүүнүүд байдаг бөгөөд байгальд шингэхгүй. Иймээс нойтон салфеткаас аль болох татгалзаж даавуун алчуурыг норгож битүү саванд хийгээд ашиглаж хэвших нь хамгийн зөв юм. Хөдөөгийн үзэсгэлэнг хамгийн ихээр гутаадаг, бохирдуулдаг хогны төрөл бол 00 цаас. Тиймээс 00 цаас хэрэглэх бол байгальд ил задгай хаяхгүй байх, мөн анхнаасаа худалдан авалт хийхдээ хөрс усанд түргэн задардаг орцтойг худалдан авах 00 цаас авах сонголтууд хийгээрэй.



ХУРУУ ЗАЙ ЦЭНЭГЛЭГЧ: Зай нь кадми, хар тугалга, мөнгөн ус, лити зэрэг хортой хүнд металлуудыг агуулдаг. 1 ширхэг хуруу зай 4 м.кв талбайг бохирдуулж, 800 мянган литр усыг бохирдуулах сөрөг нөлөөтэй учир ил задгай хаяж болохгүй аюултай хог хаягдлын төрөл болно.



ХОГНЫ УУТ: Машинд зай эзлэхгүй запаас дугуйны гадуур унжуулдаг бөх хогны уут авч ангилсан дахивар болон бусад хогоо ачиж яваад, хамгийн ойрын цэг дээр хаях эсвэл тушаах.



БОРДОО БОЛДОГ АШИГТАЙ БИЧИЛ БИЕТНЭЭР ИДЭВХЖҮҮЛСЭН БИО БЭЛДМЭЛ: Тус бодисыг хөдөө хээр явж байх үед гарсан бүх төрлийн хүнсний хог хаягдал болон 00-ын бохирдлыг хөрсөнд шим тэжээлтэй бордоо болгох зорилгоор хэрэглэнэ.



ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭХЭЭС СЭРГИЙЛЭХ БОЛОМЖГҮЙ НӨХЦӨЛД ТА ГАРГАСАН ХОГ ХАЯГДЛАА АНГИЛЖ ДАХИВАР БОЛГОН ТУШААГААРАЙ.



03

ГАРГАСАН ХОГ ХАЯГДЛАА /ДАХИВАР/ АНГИЛАХ АЛХМУУД



Аялж байх явцдаа хог хаягдал үүсэхээс сэргийлж чадахгүй нөхцөлд гаргасан хог хаягдлаа ангилж орон нутгийн дахивар нөөцийн цэгүүд дээр тушаагаарай.



ХУВАНЦАР

Хуванцар: Бүх төрлийн ундааны сав, нэг удаагийн зөөлөн хуванцар халбага сэрээ, саван шампуний сав, сүү тараг, талх, нарийн боовны зөөлөн гялгар уут, хүнсний скоч, /PET, HDPE, PVC, LDPE, PS, PP/, Styrofoam хөөсөнцөр, хатуу хуванцар савлагаанууд, уян савлагаанууд.

Анхаарах зүйлс:

- Уут, савлагааны овор хэмжээг багасгах
- Цэвэрхэн байх.



ЦААС

Бичгийн, дэвтрийн, сонингийн болон бусад төрлийн хаягдал цаас, бор цаас, картон, өндөгний сав.

Анхаарах зүйлс:

- Шохойгүй байх
- Үдээсгүй байх
- Наалтгүй байх (скочгүй)



ШИЛ/ ЛААЗ:

Хөнгөн цагаан ундаа, пивоны лааз, бүх төрлийн цонхны шил, толь, хүнсний бүтээгдэхүүн, архи пиво, ундааны шил

Анхаарах зүйлс:

- Цэвэрхэн байх
- Лаазны овор хэмжээг багасгах.



ДАХИН БОЛОВСРУУЛАГДАХ БОЛОМЖГҮЙ ХОГ ХАЯГДАЛ

ЦААС Шохойтой буюу гялгар бүрэлттэй, тос болж бохирдсон цаас.

ХУВАНЦАР Манай улсад дахин боловсруулах боломжгүй хуванцар савлагаанууд: зиплок уут, чихэр, чипсний уут гэх мэт. Гэсэн хэдий ч хуванцар нь байгаль орчинд ил задгай хаягдвал хэзээ ч шингэдэггүй учир заавал хогийн цэгт хүрч, салхиар бохирдохгүй нөхцөлд хаягдах ёстойг санаарай.

ШИЛ Автомашины хагарсан шил

04

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ АЯЛАХ БУСАД АРГА ЗАМУУД



УС, ХӨРС, АМЬТАН, УРГАМАЛ ХАМГААЛАХ ТУХАЙ БОДОЛЦООРОЙ.

Энэ үйлдэл нь байгальдаа хүндэтгэлтэй хандах хандлагаар эхэлдэг. Бохирдуулахгүй, хохироохгүй байхыг хичээх бөгөөд ая тухтай амарч зугаалахдаа ч үйлдэл бүртээ байгаль дэлхий маань хэр хохирох бол гэж бодолцох нь чухал.

- Хувцсаа угаахдаа гол, горхиноос саванд усаа авч голын усанд зайлахгүй угаах. Мөн гар аргаар бүтээсэн орц найрлага цөөтэй, эко саван, угаалгын нунтаг хэрэглэх нь бохирдол бага үүсгэнэ.
- Цэцэг ургамал тасдахгүй, мод огтлохгүй байх. Зөвхөн унасан мөчир, модны хаягдлыг гал түлэхдээ хэрэглээрэй.
- Байгальд өөрөөрөө амьдарч, нутаглаж буй шавьж хорхойноос эхлүүлээд бүх төрөл зүйлийн амьтдыг аль болох тайван байлгах, амьдрах орчинд нөлөөлөхгүй байх нэн чухал. Өвөг дээдэс маань ээтэн хоншоортой гутал бүтээж байгальдаа хэрхэн хүндэтгэлтэй хандаж байсныг санаарай.
- Бид байгаль амьтдын эзэд биш харин зэрэгцэн оршигч гэдгийг хүүхдүүддээ, бусаддаа сануулж байгаарай.



ШИНЭ ЗАМ ГАРГАХААС ЗАЙЛСХИЙХ.

Аль болох хуучин гаргасан зам хөтлөөр алхаж, машинаар явж, шинэ зам гаргахаас зайлсхийх. Шинэ зам гаргах бүрт ургамал өвс ногоо талхлагдаж, тэдгээрт дүйцэх амьд эко систем устаж үгүй болдог. Тиймээс хэдийнэ гаргасан замыг сонгон аюулгүйн дүрмээ баримтлан аялаарай.



БИЕ ЗАСАХ ТУХАЙ

Бидний биеэс ялгарах шээс нь их хэмжээний азот, фосфор гэх мэт хэрэгтэй бодисуудыг агуулж зөв компост хийсэн тохиолдолд хөрсний бордоо болох боломжтой боловч гол ус, нуур гэх мэт орчинд орсон тохиолдолд ногоон замаг болон хогийн зэрлэг ургамлыг ихээр ургуулах эрсдэлтэй. Байгальд хүндрэхэд гарах эрсдэл нь ундны усны эх үүсвэрийг бохирдуулж, байгалийн унаган төрхийг сүйтгэхэд ч нөлөөлнө. *Giardia*, *salmonella*, *E. coli*, зэрэг өвчлөл тархах, тэр ч байтугай элэгний үрэвсэлтэй хүний ялгадас хүнээс амьтанд дамждаг [3].

Мөн бидний ашигладаг ариун цэврийн цаас байгальд задрахад таван долоо хоногоос дээш, нойтон салфетка 100 жилээс дээш хугацаа зарцуулдаг байна. Ариун цэврийн цаас олон давхаргатай, өнгө будаг орох тутам энэ хугацаа уртасдаг учир түргэн задардаг, дахин боловсруулсан болон будаггүй 00 цаасыг аялалдаа авч гараарай. Харин нойтон салфеткийг хэзээ ч байгальд хаяж үлдээж болохгүй ба эцсийн хогтой нийлүүлэн хаях хэрэгтэй. Дараах үйлдлүүдийг сонгож хэвшээрэй:

- 🍌 Зориулалтын 00-той газар очих. Төв суурин газар, шатахуун түгээгүүрийн газар, цайны газар, ресторан гээд ойрхон очиж болох газар хүртлээ хүлээх.
- 🍌 Зөөврийн био, зориулалтын эко 00 авч явж, хэрэглэж занших. Бид майхан саваа бэлддэг шиг 00 бэлдэж яагаад болохгүй гэж.
- 🍌 Уул, хээр, ой модонд бие засахдаа бяцхан нүх ухаад түүндээ бие засч булдаг арга байдаг. Мэдээж ухах нүх ус болон модны үндэснээс зайдуу газар байх ёстой. Энэ үед бие засахаас өөр зүйлийг газарт булж болохгүй гэдгээ маш сайн анхаарна.
- 🍌 Эмэгтэйчүүдэд зориулсан хөнгөн бие засахад хэрэглэдэг зориулалтын алчуурууд байдаг. Бактери үүсгэгчгүй нэг тал нь ус нэвтэрдэггүй алчуур байдаг. Мэргэжлийн уулчид хэрэглэдэг. Мөн жижиг тагтай саванд энгийн зузаан алчуур хийгээд явсан ч болно.

[3] Martineau, Chantal. "Nature is calling: Here's how to poop properly in the great outdoors" Roadtrippers.com, June 5th, 2019.

URL: www.roadtrippers.com



ОРОН НУТГИЙН ХҮНСИЙГ ХЭРЭГЛЭХ ТУХАЙД БОЛОН ХҮНСНИЙ ХАЯГДЛАА ХЭРХЭХ ВЭ.

Хоол үйлдвэрлэл нь дэлхийн хүлэмжийн хийн дөрөвний нэгийг үүсгэдэг [4]. Хоол хүнс нь газар тариалан, хөдөө аж ахуйгаас бидний гар дээр иртэл маш олон шат дамжлагыг дамждаг нь та бидний экологийн ул мөрт тооцогдож байдаг. Гэвч экологийн ул мөрийн хэмжээ нь биднийг аялж байх үед үржигдэж байдаг. Хоолны үлдэгдэл овоолгод булагдах үедээ нүүрсхүчлийн давхар ислээс 21 дахин хортой метаны хийг ялгаруулдаг[5]. Аялахдаа дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээрэй:

- 🍴 Аль болох хаягдалгүй буюу хоолны үлдэгдэлгүй байхаар хоолоо захиалах, хоолоо хийх.
- 🍴 Орон нутгийн хүнс ногоог худалдан авах нь орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, тээвэр, эрчим хүч гэх мэт олон зардлаас гадна байгалийн нөөцийг хэмнэх олон ач тустай.
- 🍴 Махыг аль болох бага хэрэглэх нь уур амьсгалын өөрчлөлт болоод хүлэмжийн хий бага ялгаруулахад бидний хийж чадах томоохон алхамуудын нэг гэдгийг судалгаагаар тогтоожээ. Малыг олон жил өвс, үр тариа, усаар тэжээж арчилсны дараа нэг удаагийн хүнс болдог учир үүнийг бодолцож аль болох бага хэрэглэх чухал юм.
- 🍴 Нэгэнт хүнсний хаягдал гарсан бол хүнсний хаягдлыг хөрсний бордоо болгон ашиглах нь хамгийн зөв шийдэл юм. Гэрийн нөхцөлд бордоо болгох үйл явц нь 6-8 долоо хоног, цаашлаад жил гээд урт хугацаа зарцуулдаг тул аялагчдад бордоо болгох зориулалтын "Био Эко" ашигтай бичил биетний идэвхжүүлсэн шингэн авч явах нь хамгийн тохиромжтой. Бордоо болгох зориулалтын шингэнийг гарсан хүсний хаягдалруу шүрших байдлаар хялбархаан хэрэглэдэг тул <https://www.facebook.com/minishiidel> хаягаар хандаж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.
- 🍴 Бордоо болгох боломжгүй бол шингэн хүнсийг 00, муу усны нүх савруу хаях хэрэгтэй. Тиймээс аяллын цэгүүдэд (зарим аяллын баазуудад бий) байршуулсан хүнсний хаягдлын саванд хийгээрэй.

[4] Ritchie, Hannah; Roser, Max. "Environmental impacts of food production" Ourworldindata.org, January 2020.
URL: www.ourworldindata.org

[5] City of Edmonton. "The problem of food waste" Changeforclimate.ca, Oct. 17, 2018.
URL: www.changeforclimate.ca



ГАЛ ТҮЛЭХ, ТҮҮДЭГ АСААХАД АНХААРАХ ЗҮЙЛС.

Аялагчид аль болох гал түлэхгүй байх нь чухал бөгөөд энэ нь хөрс хамгаалах, түймрийн эрсдлээс сэргийлэх чухал алхам юм. Хэрэв зайлшгүй гал түлэх бол газраа зөв сонгох, аль болох өмнө хэрэглэж байсан голомтыг дахин ашиглана. Гал түлсэн бол цурам бүрэн унтарсан эсэхийг нягталж шалгах хэрэгтэй. Их хэмжээний үнсийг мөн байгальд үлдээж болохгүй.



МИНИМАЛИСТ БАЙХ

Минималист байх нь аялалыг тань хэд дахин илүү адал явдалтай болгоно. Мөнгөө эд зүйлд биш дурсамж бүтээхэд зарцуулаарай.

ХОГ ХАЯГДАЛГҮЙ АЯЛНА
ГЭДЭГ НЬ **ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ**
БОЛОХООС БИШ ТӨГС БАЙХ
ТУХАЙ ОЙЛГОЛТ БИШ ЮМ.



05 БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДААЛДАГ ДЭЛГҮҮРҮҮД



ЦОМХОН ЭКО ДЭЛГҮҮР

TSOMHON ECO SHOP

/хуруу зай цэнэглэгч, аяга
таваг угаагч, бие угаагч,
хулсан сойз, даавуун тор/

☎ 8017 5560

f [fb.com/tsomhon](https://www.facebook.com/tsomhon)

ГУА ШОП:

/Хулсан бүтээгдэхүүнүүд,
эко аяга таваг угаагч,
хатуу савангууд, аяны
халбага ээрээ, савнууд/

☎ 9919 1093

f [fb.com/gua.shopping](https://www.facebook.com/gua.shopping)

МИНИ ШИЙДЭЛ | MINI SOLUTIONS

☎ 7272 6000

f [fb.com/minishiidel](https://www.facebook.com/minishiidel)

ECOSY

/Хулсан бүтээгдэхүүнүүд, эко аяга
таваг угаагч, аяллын гал тогооны
хэрэгслүүд, эмэгтэйчүүдийн
ариун цэврийн аяга/

☎ 9900 8448

f [fb.com/ecosy.mongolia.9](https://www.facebook.com/ecosy.mongolia.9)

3E ECO SHOP MONGOLIA

/лаа, хулсан бүтээгдэхүүнүүд,
шүдний оо, ванны давс, органик
саван шампунь/

☎ 8611 8622

f [fb.com/3EShopMongolia](https://www.facebook.com/3EShopMongolia)

ЭКО ХУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

☎ 8892 4976

f [fb.com/profile.php?id=100057581763824](https://www.facebook.com/profile.php?id=100057581763824)

ГЭР ОРГАНИК ДЭЛГҮҮР

GER ORGANIC STORE

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 7509 9119

f [fb.com/gerorganicstore](https://www.facebook.com/gerorganicstore)

ХУЛС ШОП

/аяллын эко бүтээгдэхүүн/

☎ 9455 0150

f [fb.com/bamboo.shop13](https://www.facebook.com/bamboo.shop13)

ECO LIFE MONGOLIA

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 7277 1177

f [fb.com/zerowastemongol](https://www.facebook.com/zerowastemongol)

ECO MON

/эко гоо сайхны бүтээгдэхүүн/

☎ 7277 1177

f [fb.com/ECO-MON-107572588474815](https://www.facebook.com/ECO-MON-107572588474815)

ЭКО МУХЛАГ ОНЛАЙН ДЭЛГҮҮР

/байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүд/

☎ 9914 8892

f [fb.com/ecomukhlag](https://www.facebook.com/ecomukhlag)

ЛНАМОУР

/байгалийн гаралтай гоо
сайхны бүтээгдэхүүнүүд/

☎ 7712 0256

f [fb.com/lhamourskincare](https://www.facebook.com/lhamourskincare)

ECO TIPS ESHOP

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 8804 7486

f [fb.com/Eco-tips-eshop-113407883863328](https://www.facebook.com/Eco-tips-eshop-113407883863328)

SIMPLENESS

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 9973 4300

f [fb.com/simplessness.eco](https://www.facebook.com/simplessness.eco)

ECO BAR MONGOLIA

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ -

f [fb.com/eco.bar.mongolia](https://www.facebook.com/eco.bar.mongolia)

LAPERLA-MONGOLIANPRODUCTS

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 9955 2227

f [fb.com/laperlamongolia](https://www.facebook.com/laperlamongolia)

BADAMIN BRAND MONGOLIA

/хатуу үс арчилгааны
бүтээгдэхүүнүүд/

☎ 7766 0777

f [fb.com/Badamin-Brand-Mongolia-1861008914187403t](https://www.facebook.com/Badamin-Brand-Mongolia-1861008914187403t)

NOMADIC BEAUTY

/байгалийн гаралтай үс, бие
арчилгааны бүтээгдэхүүнүүд/

☎ 7715 6833

f [fb.com/info.nomadicbeauty](https://www.facebook.com/info.nomadicbeauty)

GOO BRAND

/олон нэр төрлийн органик гоо
сайхны бүтээгдэхүүнүүд/

☎ 7777 7755

f [fb.com/GooCosmetics](https://www.facebook.com/GooCosmetics)

ЦОМХОН ЭКО ДЭЛГҮҮР

/байгальд ээлтэй
бүтээгдэхүүнүүд/

☎ 8017 5560

🌐 tsomhon.mn/products/17563

ЦЭГЦ ДААВУУН ТОР

/хэвлэлттэй даавуун торнууд/

☎ 8895 1669

f [fb.com/HevleltteiDaavuunTor](https://www.facebook.com/HevleltteiDaavuunTor)

ДААВУУН ТОР

/Сав баглаа боодол/

☎ 7600 1919

f [fb.com/uutmnn](https://www.facebook.com/uutmnn)

BABY PANDA MONGOLIA

/Угаадаг эко живх/

☎ 8989 1242

f [fb.com/babypandamn](https://www.facebook.com/babypandamn)



06

ОРОН НУТГИЙН ДАХИВАР ТУШААХ БАЙРШЛУУД
БОЛОН ХОЛБОО БАРИХ МЭДЭЭДЭЛ

/2022 оны байдлаар/

АЙМГУУД	Байгууллага, хариуцсан иргэдийн нэр	УТАС	БАЙРШИЛ
АРХАНГАЙ	Архангай аймгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн.	9966 6324	
	Ч.Эрдэнэбаяр (Шил, лааз, төмөр, хуванцар сав)	9574 9576	Тариат сум
	Б. Сайнхүү (Бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	9577 7337 9807 9797 8885 1931	Хайрхан сум
	Мөнхдэлгэр	9993 2344	Ихтамир сум
	Д.Будрагчаа (Төмөр, ширэм, хайлш, гууль, зэс, аккумулятор)	9546 5164	Жаргалант сум
	Ж.Төгсцогт (Зөвхөн металын төрлийн хоёрдогч түүхий эд)	8816 9805 8869 9805	Өгийнуур сум, Жимстэй баг, Орхон хороолол
	П.Ганболд (Бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	9987 3751	Цахир сумын төв
	С. Баттулга (Төмөр, ширэм, хайлш, гууль, зэс, аккумулятор, лааз)	9933 3323	Эрдэнэбулган сум, 5р баг
	Н.Баттогтох (Бүх төрлийн хуванцар, лааз)	9915 4589	Эрдэнэбулган сум
БАЯН-ӨЛГИЙ	БОАЖГазрын дарга	9942 3066	
БАЯНХОНГОР	Уранчимэг “Хонгор Дуулим ХХК” (бүх төрлийн хуванцар, гялгар уут, хөөсөнцөр, цаасан хайрцаг, бүх төрлийн шил, баттерей, электрон барааны хаягдал)	8008 8565	Баянхонгор сум
	Шизү Мөн Тогтвортой Хөгжлийн Нийгэмлэг ТББ “Эко Баянхонгор” төсөл	8805 1515	

АЙМГУУД	Байгууллага, хариуцсан иргэдийн нэр	УТАС	БАЙРШИЛ
БУЛГАН	Булган аймгийн Байгаль орчны газар	7034 3325 7034 3322	
	Булган аймгийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн	9971 8018	Аймгийн төв, төвийн зүүн урагш байгууламж
	П. Сүхбаатар (Булган сумын ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр)	8054 3414 9914 9627 9666 3414	Сумын төвийн зүүн талд
	Булган сумын ТҮА	9967 3636	
	Экосум ТББ	8014 2043	Хишиг-Өндөр сум
ГОВЬ-АЛТАЙ	Хадбаатар (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	9972 5888	Аймгийн төв, Халдвартын эмнэлэгийн ард
	Очир “Төмөрт нуруу ХХК” (хоёрдогч түүхий эд, шилнээс бусад)	9997 1819 9997 1918	Аймгийн төв
ГОВЬСҮМБЭР	Ц.Болдбат “Чойр дахивар эрдэнэ хоршоо”	99003116, 99854392	Чойр хотын төв
ДАРХАН-УУЛ	Аззаяа (байгаль орчин, хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	99399992	Дархан-Уул
	“Сан Оргиу ХХК” (гялгар уут)	99493044	Дархан-Уул, 15-р баг, Мангирт хороолол, 1-111
	“Бурхантын түрүү ХХК” (бүх төрлийн хуванцар сав, гялгар уут, лааз)	99934787 88589094	Дархан-Уул, 8-р баг, Дэвшил
ДОРНОД	Урантогос (Хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	99034847	
	Хилчинбаатар “Талын алтан уул ХХК” (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	88589348 88085106	Аймгийн төв, 2-р баг Жуковын 4-4
	Баяржаргал (хаягдал метал, HDPE хуванцар, гялгар уур, архины шил, лааз, ус ундааны хуванцар сав)	99145886	Хэрлэн сум, 6-р баг

АЙМГУУД	Байгууллага, хариуцсан иргэдийн нэр	УТАС	БАЙРШИЛ
ДОРНОГОВЬ	Бат-Эрдэнэ (Хүрээлэн буй орчин хариуцсан мэргэжилтэн)	88085106	
	Ган-Эрдэнэ “Эко говь” (хуванцар, лааз, гялгар уут)	99145886	Сайншанд, 3-р баг
ДУНДГОВЬ	Золжаргал (Хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	98904156	
	Э.Эрдэнэжаргал Баялаг төвийн үүсгэн байгуулагч	88018075 99980020 99980021	Баялаг төв, Дундговь аймаг Сайнцагаан сум,
ЗАВХАН	БОАЖГ ын дарга	99990298	
ОРХОН	Ганцогт (Эрдэнэт хотын ЗАА дарга Хог хаягдлын менежмент)	99351733	
	Нацагдорж (бүх төрлийн хуванцар, гялгар уут болон бусад хоёрдогч түүхий эд)	99354477	Эрдэнэт хот, Дөмөг захын урд
	Батзаяа (бүх төрлийн архины шил, лааз)	99352666	Эрдэнэт хот, Дэнж баг
ӨВӨРХАНГАЙ	Даваатогтох (Цэмцгэр төв)	95083737	Арвайхээр,
	Д. Лүмбэ Эко цэнэ төв (бүх төрлийн түүхий эд)	99320981 88320981 96066618	Арвайхээр
	Сүх-Өлзий (Арвайхээр тохижилт үйлчилгээний төв)	95166565	
ӨМНӨГОВЬ	Хатантөмөр (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	86116061	Даланзадгад, 2-р баг, Хан-Уул 17-6
	Цогнэмэх (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	88601198	Цогт цэций сумын төв, Ивээл төв
	“Ханбогд Waste Management Center ХХК” (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	99286586	Ханбогд сумын төв

АЙМГУУД	Байгууллага, хариуцсан иргэдийн нэр	УТАС	БАЙРШИЛ
СҮХБААТАР	БОАЖ газар	70518892	
СЭЛЭНГЭ	Түнхэл тогтвортой хөгжлийн төв ТББ (хуванцар, лааз, шил, гялгар уут)	86844844	Сэлэнгэ аймаг, Баатарваань гудамж 109 тоот (Ням гариг бүрийн 14-17 цагийн хооронд)
	Анхтуяа (хаягдал гялгар уут)	96505002, 94244449	Зүүнхараа сум, Баянхангай
ТӨВ	Ш.Энхтайван Эко зоргол ХХК (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	88956673	Төв аймаг, Зуунмод сум
	Н.Ганчимэг Ятуут дэлгүүр (арьс шир, бүх төрлийн хаягдал метал)	80829292	Төв аймаг, Угтаалцайдам
	М.Од (хуванцар, гялгар уут, шил, лааз, бохирын сав, машины)	99755814	Төв аймаг, Эрдэнэсант сум
	Мөнхгэрэл (пакет, гялгар уут, шил, хуванцар сав, лааз)	99673707	Төв аймаг, Баянцогт сум
	Баттулга Үлэмж Хүдэр ХХК (хаягдал аккумулятор)	99089969	Төв аймаг, Баянцогт сум
УВС	Батмөнх (хуванцараас бусад бүх хоёрдогч түүхий эд)	99075838	Увс аймгийн төв
	Алтанзул (бүх төрлийн хоёрдогч түүхий эд)	95227542 99065213	Увс аймгийн төв (хогны цэгийн хажууд, гэр хороолол 8-р гудамж)
ХОВД	Цэвээн-Ойдов (хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	99065457	
ХӨВСГӨЛ	БОАЖгазар	70384909	
	Энхдэлгэр (хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	89018530	
	Золзаяа “Бэртэс Ээж” ХХК (Хайлш, хөнгөн цагаан, лааз, шил, хуванцар сав, гялгар уут)	99599440	Баянзүрх сумын төв

АЙМГУУД	Байгууллага, хариуцсан иргэдийн нэр	УТАС	БАЙРШИЛ
ХӨВСГӨЛ	Ж.Сайнбаяр Хүн байгаль бүлэг (Олон нийтийн байцаагч) (Шил лааз хуванцар паркет, зэс, гууль, цайр, хөнгөн цагаан, хайлш, гялгар уут)	86815775	Цагаан-Үүр сум, Хөвсгөлийн тусгай хамгаалалтын газрын пост, Чандмань сум
	С.Эрдэнэтуяа (Шил лааз хуванцар паркет, зэс, гууль, цайр, хөнгөн цагаан)	86168801	Цагаан-Үүр сумын ТӨВ
	Б.Ганчимэг (Хуванцар, лааз, гялгар уут, шил)	95053015	Мөрөн сум, Элстийн хогийн цэгийн ард
	Ч.Бямбацогт (Хайлш, зэс, гууль, хар төмөр, лааз, аккумулятор)	88318514	Мөрөн сум, 4-15-17
	Д.Жаргалсайхан (Хайлш, зэс, гууль, хар төмөр, лааз, аккумулятор)	89613761	Мөрөн сум, 3-22-11
ХЭНТИЙ	Баярцэцэг (хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)	88024663	
	Эрдэнэбат “Бор-Өндөр хот тохижилт” ТБАГУТҮГ (бүх төрлийн хуванцар, гялгар уут, лааз, шил)	95050044	Бор-Өндөр сум

07 ХОГ ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ААН

Од пластик ХХК

Бүтээгдэхүүн:

- HDPE үрэл
- Хогны уут



Хэв хашмал хуванцар ХХК

Бүтээгдэхүүн:

- PP, PE үрэл
- Барилгын хэв хашмал
- Гэр ахуйн бараа
- Сувинер



Ансэхэ ХХК

Бүтээгдэхүүн:

- Цахилгааны хамгаалалтын хоолой
- HDPE



Сэртэн хангай ХХК

Бүтээгдэхүүн:


- HDPE үрэл
- Хогны уут



Метро пласт ХХК

Бүтээгдэхүүн:

- Вакум цонх,
- Цэвэр, бохир усны хоолой



Сан-Оргиу ХХК

Бүтээгдэхүүн:


- Сандал
- Траншейний таг
- Подон
- Хайс
- Шон



Идэр ивээлт ХХК

Бүтээгдэхүүн:

- HDPE үрэл
- Хогны уут



Пластик центр ХХК

Бүтээгдэхүүн:

- Нүхэн жорлонгийн сав
- Шилжүүлэгч таг
- Траншейний таг
- Бүх төрлийн цутгамал хуванцар



Тэр Их Нуур ХХК

Бүтээгдэхүүн:

- Бохирын болон усны хоолой



Ти Эм Эл ХХК

Бүтээгдэхүүн:

- Импорт орлох PET
- Хуруу шилэн бэлдэц



Мултипак ХХК

Бүтээгдэхүүн:

- Багцлагч уут
- Пакет



Сод Түм ХХК

Бүтээгдэхүүн:

- Цахилгааны хамгаалалтын хоолой
- HDPE



Түмэн эгшиг ХХК

Бүтээгдэхүүн:

- Барилгын материалын хагас бэлдэц



ОБ Пластик ХХК

Бүтээгдэхүүн:

- Гялгар уут хэвлэлтэй
- Багцлагч уут
- Сав баглаа боодол



Цэцүүх Трөйд ХХК

Бүтээгдэхүүн:

- Хуванцар үрлэн түүхий эд



Грийн пластик УБ ХХК

Бүтээгдэхүүн:

- Хогны уут, сав баглаа боодол



Инахис ХХК

Бүтээгдэхүүн:

- Резинэн хавтан



Пийс стийл групп ХХК

Бүтээгдэхүүн:

- Усан онгоцны жин тэнцвэржүүлэгч



МСРТ ХХК

Бүтээгдэхүүн:

- Шорлогны түлш



Хай би ойл ХХК

Бүтээгдэхүүн:

- Моторын масло
- М-100 мазут



Мон Пити Ойл ХХК

Бүтээгдэхүүн:

- М-100 мазут



Ногоон газар трейдинг” ХХК

Бүтээгдэхүүн:

- Полистрол хавтан, блок



Эко Тайхи ХХК

Бүтээгдэхүүн:

- Компост бордоо



Ти Жэй Эн Ресайклин ХХК

Бүтээгдэхүүн:

- Компост бордоо



Үлэмж Хүдэр ХХК

Бүтээгдэхүүн:

- Хар тугалган
гулдмай



“Алтан Оршихуй групп” ХХК

Бүтээгдэхүүн:

- Дизель түлш
- М-100 мазут



08 ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ОЛОН НИЙТИЙН БҮЛГҮҮД

КАРИТАС ЧЕХ РЕПАБЛИК ОУТББ:

- ☎ 7013 5899
- fb.com/CaritasCzechRepublicInMongolia
- 🌐 <https://mongolia.charita.cz/>

ЭКОСУМ ТББ:

- ☎ 8014 2043
- fb.com/Ecosoum

МОНГОЛЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОЛБОО:

- ☎ 8911 6570
- fb.com/MongolianNationalRecyclingAssociation

МОНГОЛЫН ХУВАНЦАР ДАХИН БОЛОВСРУУЛАГЧДЫН ХОЛБОО:

- ☎ 9982 3222

МОНГОЛЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХОЛБОО:

- ☎ 7017 3099, 7017 0399
- twitter.com/monhazardous
- fb Аюултай Хог Хаягдлын Холбоо

ӨНГӨ НЭМ ТББ:

- ☎ 9900 2058
- fb.com/ungunem

ХОГГҮЙ МОНГОЛ ТББ:

- ☎ 9510 4373
- fb.com/NoPlasticMongolia

НОГООН СЭТГЭЕ КЛУБ:

- ☎ 8088 1308
- fb.com/ThinkGreenMongolia

ХОГОО БАГАСГАЯ БҮЛГЭМ:

- fb.com/groups/2127875217449095

ХОГОО АНГИЛЬЯ БҮЛГЭМ:

- fb.com/groups/hogooangiljungunem

ZERO WASTE MONGOLIA:

 9501 6555

 fb.com/ZeroWasteMGL


ZERO WASTE CLUB:

 9983 3629

 fb.com/Zerowasteclubmn

ХОГОО ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ АНГИЛЖ ХЭВШЬЕ:

 7000 2444


 fb.com/groups/1651914868202992

3R4UB:

 fb.com/3R4UB

УЛААНБААТАР ХОТЫН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ:

 7011 1220

 fb.com/Эерэг-давалгаа-UB-waste-111263011238817

 www.waste.ub.gov.mn

ZERO TO HERO

 8966 1565


 fb.com/zero2heroez

БИД БОЛ ДЭЛХИЙ - ХҮМҮҮС

 fb.com/WeAreTheEarthmen

БИ БОЛ ДЭЛХИЙ - ХҮН

 8976 8466

 fb.com/EarthmanBook



📍 Монгол улс, Улаанбаатар-15170,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Аризона оффис төв, 35 тоот

✉ zwm.msdb@gmail.com

☎ +976 9501 6555, +976 9502 3489, +976 9503 3489

f [fb.com/MongolianSustainableDevelopmentBridge](https://www.facebook.com/MongolianSustainableDevelopmentBridge)

🌐 www.plastic-recycling.mn